

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.10.28

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Tesla компанийн 3-р улирлын ашиг хүлээлтээс давж, хувьцааны ханш нь 21.97%-иар өслөө.
- Beige Book тайлан АНУ-д эдийн засгийн өсөлт удааширч байгааг харууллаа.
- Хятадын арилжааны банкнууд 1 болон 5 жилийн хугацаатай зээлийн үндсэн хүүг тус бүр 25 суурь нэгжээр буурууллаа.
- Хятадын 16-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 9-р сард 17.6%
- IMF энэ жил дэлхийн эдийн засгийн өсөлтийг 3.2%-д хүрч удааширна гэж таамаглаж байгаа нь дэлхийн томоохон үйлдвэрлэгч, экспортлогч гүрэнд томоохон сорилт болж байна.

2024 он 10-р сарын 28

Dow Jones	42,114.40
S&P 500	5,808.12
Nasdaq	18,518.61
DAX	19,463.59
FTSE 100	8,248.84
S&P/ASX 200	8,210.70
HANG SENG	20,574.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-0.61%	-1.90%	-0.47%	11.74%	29.91%	17.57%
S&P 500	-0.03%	-0.78%	1.22%	21.77%	41.06%	26.12%
Nasdaq	0.56%	-0.12%	2.20%	23.36%	46.47%	19.49%

2024 оны 10 сарын 28-ны 11:30

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.11%	0.01%	-0.05%	16.19%	32.52%	24.06%
FTSE 100	-0.25%	-0.83%	-0.86%	6.67%	13.13%	13.97%

2024 оны 10 сарын 28-ны 11:30

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.01%	-1.58%	0.00%	8.19%	20.29%	12.13%
Hang Seng	-0.04%	0.45%	-0.30%	20.66%	18.23%	-18.94%

2024 оны 10 сарын 28-ны 11:30

ЗӨВЛӨМЖ

3-р улирлын тайлан зарлагдаж эхэллээ:

Тайлангаас өмнө хувьцаа авах нь компани хүлээлтийг давж чадвал ашиг олох боломжтой боловч орлогын хүлээлтэд хүрээгүй тохиолдолд огцом буурах эрсдэлтэй.

Эрсдэлээс зайлсхийх хүсэлтэй хөрөнгө оруулагчид орлогын тайланг хүлээгээд дараа нь худалдан авалт хийх нь илүү аюулгүй сонголт юм.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### АНУ-ын хувьцааны зах зээл уналт үзүүлэв

Сүүлийн зургаан долоо хоног дараалан өсөлттэй байсан S&P 500 индекс өнгөрсөн долоо хоногт 0.78%-ийн уналттай хаагдаад байна. Харин технологийн салбарын компаниудыг багтаадаг Nasdaq индекс бага зэргийн өсөлтийг үзүүлж, бусад жижиг салбарын хувьцаануудаас давсан гүйцэтгэлийг хийлээ. Томоохон компаниудын 3-р улирлын тайлан зарлагдаж зах зээл тэр чигээрээ компаниудын орлогын тайлангаас хамааралтай нөхцөл байдалтай байна.

### Tesla компанийн хувьцаа өндөр өсөлтийг үзүүллээ

Tesla компанийн 3-р улирлын ашиг хүлээлтээс давж, хувьцааны ханш нь 21.97%-иар өслөө. Тодруулбал, нэгж хувьцаанд ногдох ашиг 0.72 ам.доллар (\$2.51 тэрбумын цэвэр ашиг) болж шинжээчдийн \$0.59 (\$2.01 тэрбумын цэвэр ашиг) хүлээлтээс давжээ. Мөн тайлангийн үеэр Elon Musk 2025 онд Калифорни, Техас мужид автомат жолоодлоготой такси үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөж буйгаа танилцуулсан байна.

### Beige Book тайлан эдийн засгийн өсөлт удааширсныг харууллаа.

Өнгөрсөн долоо хоногт эдийн засгийн чухал мэдээнүүд харьцангуй бага байсан бөгөөд ХНС-ийн бүс бүрийн эдийн засгийн нөхцөл байдлыг жилд 8 удаа танилцуулдаг Beige Book тайлан АНУ-ын ихэнх бүс нутагт эдийн засгийн өсөлт удааширч байгааг харуулсан байна. Тайланд ажиллах хүчний эрэлт бага зэрэг буурч, инфляц тодорхой хэмжээгээр тогтворжсон тухай дурдсан байна. Мөн ХНС хүүгээ дараагийн 1 жилийн хугацаанд 1.25%-иар бууруулах хүлээлт буурсан байна.

Харин энэ долоо хоногт 10-р сарын ажилгүйдлийн түвшин болон NFP мэдээнүүд зарлагдахаар хүлээгдэж байна.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хятадын хувьцааны зах зээл дэмжлэг авч өсөв

Хятадын эдийн засгийг дэмжих зорилгоор Төв банкны хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дараа Хятадын хувьцааны зах зээл тогтворжлоо. Shanghai Composite индекс 1.17%-иар өсөж, CSI 300 индекс 0.79%-ийн өсөлт үзүүлжээ. Харин Хонг Конгийн Hang Seng индекс 1.03%-иар буурсан байна.

### Төв банк хөрөнгийн зах зээлдээ нэмэлт дэмжлэг үзүүлээ

БНХАУ-ын Төв банк (PBOC) банкны системд 700 тэрбум юанийн хөрөнгө оруулалт хийж, дунд хугацааны зээлийн механизмаар (MTLF) хэрэгжүүлсэн зээлийн хүүг 2%-д хэвээр үлдээв. Гэхдээ 11-р сард 789 тэрбум юанийн зээл дуусах тул энэхүү үйл ажиллагаа аравдугаар сард санхүүгийн системээс 89 тэрбум юанийн цэвэр мөнгөн урсгал гаргасан байна. Өмнө нь Төв банк MTLF зээлийн хүүг 30 суурь нэгжээр бууруулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих арга хэмжээ авч байсан юм.

### Хятадын ажилгүйдлийн түвшин болон хэрэглээний зээлийн хүү буурав

Хятадын арилжааны банкнууд 1 болон 5 жилийн хугацаатай зээлийн үндсэн хүүг тус бүр 25 суурь нэгжээр бууруулан, 3.1% болон 3.6%-д хүргэж, ипотекийн зээл болон бусад хэрэглээний зээлийг хүүг буурууллаа. Энэ нь Төв банкнаас 9-р сарын сүүлчээр танилцуулсан эдийн засгийн өдөөлтийн хүрээнд хийгдсэн бөгөөд ирээдүйд зээлийн шаардлагад нийцүүлэн нөөцийн шаардлагын түвшнийг дахин бууруулах магадлалтай гэж мэдээлжээ.

Мөн Хятадын 16-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 9-р сард 17.6% болж, өмнөх сарын 18.8%-иас буурсан байна.

Олон Улсын Валютын Сангаас (IMF) энэ жил дэлхийн эдийн засгийн өсөлтийг 3.2%-д хүрч удааширна гэж таамаглаж байгаа нь дэлхийн томоохон үйлдвэрлэгч, экспортлогч гүрэнд томоохон сорилт болж байна.

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



## ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning October 21, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 DYNEX CAPITAL INC. LU	 SAP NUE	 verizon GM	 ENPHASE STX	 BOEING VRT	 TESLA Lam RESEARCH	 UPS AAL	 DEXCOM DECK	 New York Community Bancorp Inc. CL	
 LUFAX HBT	 NUCOR WEB	 gm MGM	 SEAGATE TXN	 VERTIV T	 IBM NOV	 American Airlines NDAQ	 DECKERS BRANDS WDC	 PIPER SANDLER BAR	
 HBT Financial KSP	 Berkley LOG	 3M RJA	 TEXAS INSTRUMENTS BEN	 AT&T KO	 serviceNow NEM	 Nasdaq LUV	 Western Digital S	 Booz   Allen   Hamilton SALA	
 Kaspi.kz SASR	 logitech ZION	 RTX GE	 enova BKR	 Coca-Cola GEV	 Newmont CElestica	 Southwest LQ	 SKECHERS BOYD	 SALA CNC	
 Sandy Spring Banc PRFC	 ZIONS BANCORPORATION BOK	 GE Aerospace FCX	 Baker Hughes VRS	 nextera ENERGY TMO	 Celestica TMO	 LQ HONEYWELL	 BOYD KINSALE	 CENTENE AON	
 PREFERRED BANK GRNY	 BOK FINANCIAL MEEP	 Polaris VRS	 volaris VRS	 ThermoFisher Scientific CME	 T-Mobile VIXX	 Honeywell LTH	 VALE COUR	 AON WISDOMTREE	
 Guaranty Bank & Trust NWKY	 MEDPACE WASH	 Quest Diagnostics DOX	 DJB JBT	 CME Group BSX	 VIKING QSS	 LIFE TIME OSIS	 coursera SAM	 WISDOMTREE NWL	
 SANDVIK NWKY	 RLI HXL	 Denny's DENN	 Robert Half RHI	 Boston Scientific BD	 Sands LVS	 LIFE TIME OSIS	 BOSTON BEER CO. SAM	 newell BRANDS NWL	
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2024 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning October 28, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 onsemi PHS	 Ford TMX	 SoFi PYPL	 AMD GOOG	 Lilly CAT	 Microsoft META	 Uber PFIN	 amazon AAPL	 fuboTV FV	
 PHILIPS CX	 TransMedics WM	 PayPal MCD	 Alphabet GOOGL	 CATERPILLAR HUM	 Meta COIN	 PELTON MA	 Apple AAPL	 Chevron CVX	
 CEMEX PRCT	 WM CON	 McDonald's BP	 Snap Inc. CMG	 Humana GPH	 coinbase ROOB	 mastercard MEX	 intel INTC	 ExxonMobil XOM	
 PROCEPT bioRobotics CNP	 cadence FTV	 bp PFE	 CHIPOTLE V	 globalpayments TRN	 Robinhood ETSY	 MERCK COP	 ATLASSIAN ICFI	 wayfair D	
 CenterPoint Energy FMS	 VFC RMS	 Pfizer RCL	 VISA FSLR	 TRINITY CAPITAL ADP	 Etsy NOVA	 ConocoPhillips NO	 ICF TREE	 Dominion Energy CHTR	
 FEMSA BRC	 VF CORPORATION BRO	 Royal Caribbean Group CROX	 First Solar RST	 ADP BIB	 sunnova CUNA	 Altria SR	 lendingtree EGO	 Charter LYB	
 Bank of Marin AKR	 Rambus BRO	 croc's THC	 reddit JBLU	 Biogen EAT	 CARVANA RST	 SiriusXM NCH	 elderado gold ARGX	 lyondellbasell SBS	
 ACADIA BOH	 Brown & Brown LEU	 Tenet Health EPD	 QORVO EA	 Brinker International JKS	 I O T ROKU	 NORWEGIAN CRUISE LINE RBLX	 ardelyx FIDUS	 SIMON OXL	
 Bank of Hawaii ARLP	 Centrus AMKR	 jetBlue CB	 Electronic Arts CHUBB	 Jinko Solar WNG	 Roku SEIU	 RQBLX SKYW	 FIDUS INVESTMENT CORPORATION SKYW	 OXFORD LANE PPL	
 ALLIANCE RESOURCE PARTNERS LP AMKR	 Amkor Technology AMKR	 Enterprise Products Partners LP EPD	 CHUBB CB	 Starbucks SBUX	 ESTEE LAUDER COMPANIES EL	 SkyWest SKYW	 SkyWest SKYW	 ppl PPL	
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2024 Earnings Whispers	